



ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА

НҮБ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРӨЛЖСӨН АГЕНТЛАГ



НИЙГМИЙН ШУДАРГА ЕС
ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР

Нийгмийн шударга ёсыг түгээн дэлгэрүүлбэ!

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрөлжсөн агентлаг юм. ОУХБ олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг тогтоож, хөдөлмөрийн хүрээний эрхүүдийг хангах, зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөлмөрийн асуудлаарх нийгмийн түншлэлийг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

газар нь Швейцар улсын Женев хотноо байрладаг. Дэлхийн 40 гаруй оронд байрлах төлөөлөгчийн газруудаараа дамжуулан техникийн зөвлөгөө, дэмжлэгийг гишүүн орнууддаа үзүүлж байна.

Олон улсын хөдөлмөрийн чуулган жил бүрийн 6 дугаар сард Женев хотноо хуралдаж олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ тогтоохын зэрэгцээ ОУХБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталдаг.

ОУХБ нь Засгийн газар, ажил олгогч, ажилчдын төлөөллийг холбосон гурван талт онцлог бүтэцтэй. ОУХБ нь 187 гишүүнтэй, НҮБ-ын хамгийн анхны төрөлжсөн агентлаг юм. ОУХБ-ын Нарийн бичгийн дарга нарын

ОУХБ-ын эрх барих дээд байгууллага нь Удирдах Зөвлөл бөгөөд жилд гурван удаа Женев хотноо хуралддаг.



ТҮҮХ СӨХВӨЛ



ОУХБ нь нийгмийн шударга ёсыг тогтоолгүйгээр бүх нийтийн тогтвортой энх тайван байдлыг хангах боломжгүй хэмээх итгэл үнэмшилд тулгуурлан Дэлхийн нэгдүгээр дайныг төгсгөл болгосон Версалийн гэрээний хүрээнд байгуулагдсан юм.

1919



“Филадельфийн Тунхаглал”-аар хөдөлмөр бол бараа бүтээгдэхүүн биш гэдгийг тунхаглаж, энэ хүрээнд төр баталгаажуулах ёстой хүний үндсэн болон эдийн засгийн эрхийг тодорхойлов.

1944



ОУХБ нь Нэгдсэн үндэстний байгууллагын анхны төрөлжсөн агентлаг боллоо.

1946



ОУХБ Нобелийн Энхтайвны шагнал хүртэв.

1969

Зохистой хөдөлмөрийг дэмжье!

АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ

Хөрөнгө оруулалт, бизнес, ур чадвар, ажлын байр, тогтвортой амьжиргааг сайжруулахад чиглэсэн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих.



НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ ДЭМЖИХ

Бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн маргаан зөрчлөөс зайлсхийх, харилцан ойлголцсон эе эвтэй нийгмийг цогцлооход ажилчид, ажил олгогчдын төлөөллийн хүчтэй, бие даасан байгууллагууд чухал үүрэгтэй.



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг аюулгүй нөхцөлөөр адил хангаж, зохистой хугацаанд амрах, чөлөөт цагтай байх боломжийг бүрдүүлэх, гэр бүл, нийгмийн үнэт зүйлсийг нь хүндэтгэн үзэх, орлогоо алдсан буюу орлого нь буурсан тохиолдолд хангалттай нөхөн олговор авах, эрүүл мэндийн чанартай үйлчилгээнд хамрагдах баталгааг бүрдүүлэх.

ХӨДӨЛМӨРИЙН ХҮРЭЭНИЙ ЭРХҮҮДИЙГ ХАНГАХ

Ажилчдын эрхийг хүлээн зөвшөөрч, нийт ажилчид, ялангуяа дэмжлэг, туслалцаа шаардлагатай буюу бага орлоготой ажилчдын эрхийг хуулиар хамгаалж, төлөөлөл, оролцоог нь баталгаажуулах.



Хөдөлмөрийн суурь хэм хэмжээг “Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн тухай Тунхаглал”-аар тогтоов.



“Шударга даяарчлалын төлөөх нийгмийн шударга байдлын тухай Тунхаглал”-аар даяарчлалын шинэ эрин үед ОУХБ-ын алсын харааг шинэчлэн тогтоов.



“2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т бүх нийтийн зохистой хөдөлмөр нь тогтвортой, хүртээмжтэй өсөлт, хөгжлийн бодлогын гол цөм болж туссан.



ОУХБ нь 100 жилийн ойн босгон дээрээ дараагийн зуунд тулгарч болзошгүй бэрхшээл сорилтыг даван туулах хэд хэдэн чухал санаачлагуудыг эхлүүлж байна.

1998

2008

2015

2019



"Хүртээмжтэй, шударга, тогтвортой, энх тайван нийгмийг бий болгохын тулд бүх хүнд зохистой хөдөлмөр эрхлэх боломж олгох нь хэзээ хэзээнээс илүү чухал байна. Хувьсан өөрчлөгдөгдөж буй хөдөлмөрийн ертөнцөд Засгийн газар, ажилчид, ажил олгогчид өөрсдийн хүсэж мөрөөдөж буй хөдөлмөрийн ирээдүйг хамтдаа бүтээх ёстой."

*Гай Райдер,
ОУХБ-ын Ерөнхий Захирал*

Олон улсын хөдөлмөрийн байгууллага

Department of Communication and Public Information

4, route des Morillons
CH-1211 Geneva 22
Switzerland

Tel: +41 22 799 79 12

Fax: +41 22 799 85 77

Email: communication@ilo.org

Visit: www.ilo.org

Follow us:



НИЙГМИЙН ШУДАРГА ЕС
ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР